



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/41

Шивээговь сум

Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах,  
дуудлага худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах, дуудлага худалдаа явуулах журам”, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2020 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд батлагдсан Ерөнхий боловсролын сургуулийн урд талд байршилтай 0,09 га газрыг Сургалтын төвийн зориулалтаар газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдааг журмын дагуу цахим хэлбэрээр зохион байгуулж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж, ашиглуулахыг зөвшөөрсүгэй.

2. Дуудлага худалдааг иргэд, олон нийтэд зарлан мэдэгдэж, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Газрын даамал /Э.Баярмагнай/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ